



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/822

Булган сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд “Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдаалахыг хориглох тухай” захирамж нь хуулиар хориглосон заалтыг давхардуулан хэрэглэсэн, аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон шинжтэй бөгөөд хууль тогтоомжид нийцээгүй болох нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2023 оны 05 дугаар сарын 17-“ны өдрийн 01/762 дугаар албан бичгээр тогтоогдож байгаа тул аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/114 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

2. Олон нийтийг хамарсан шийдвэр гаргахдаа холбогдох байгууллага, иргэдээс санал авч, тусгаж байхыг Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон мэргэжилтнүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ